



ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Улаанбаатар хот
2018 он

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Гарын авлагыг боловсруулсан:

М.МӨНХЖАРГАЛ, “Оюуны Инноваци” ТББ-ын судлаач

Б.ТӨРБОЛД, “Оюуны Инноваци” ТББ-ын судлаач

© Нээлттэй Нийгэм Форум, 2018

Гарын авлагыг ашгийн бус зорилгоор хуулбарлан ашиглахыг зөвшөөрнө. Энэ тохиолдолд ННФ-ын нэрийг дурдана уу.

ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	4
НЭГ. ШҮҮХИЙН АЖИГЛАЛТ	6
ХОЁР. ШҮҮХИЙН АЖИГЛАЛТАД БЭЛТГЭХ	8
ГУРАВ. ШҮҮХИЙН АЖИГЛАЛТ ХИЙХ	12
1. Шүүх хуралдааны нийтлэг журам	12
2. Шүүх хуралдааны явц	19
ДӨРӨВ. ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ҮР ДҮНГ БАТАЛГААЖУУЛАХ ..	22
ХАВСРАЛТ	24
Шударга шүүхийн стандарт	24
Эрүүгийн хэргийн шүүхийн ажиллагаа	29
Иргэний хэргийн шүүхийн ажиллагаа	32
Захиргааны хэргийн шүүхийн ажиллагаа	34
Шүүх хуралдааны ажиглалтын жишиг хуудас	36

ӨМНӨХ ҮГ

Нээлттэй Нийгэм Форумын 2008 оноос хэрэгжүүлж ирсэн “Шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд олон улсад амжилттай хэрэгжүүлж туршсан шүүхийн ажиглалтын арга зүйг нутагшуулж 2010, 2014 болон 2017 онд шүүхийн ажиглалтын төслийг орон нутгийн иргэний нийгмийн төлөөлөл, хууль зүйн клиник сургалтын төвийн багш оюутнуудын оролцоотой хэрэгжүүлсэн юм.

Орон нутгийн иргэдэд өөрийн нутаг орны шүүхийн үйл ажиллагаанд ажиглалт хийх боломжоор хангах үүднээс Монгол Улсын 21 аймгийн иргэний нийгмийн байгууллагын ажилтнуудад бүсчилсэн сургалт зохион байгуулж, шүүхийн ажиглалт хийх арга зүйг танилцуулж, туршилт төслийг хэрэгжүүллээ. Цаашид шүүхийн ажиглалтыг иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааны нэг хэсэг болгон хөгжүүлэхэд арга зүйн нэгдсэн гарын авлага боловсруулан түгээх нь чухал юм. Тиймээс энэхүү хялбарчилсан гарын авлагыг Нээлттэй Нийгэм Форумын захиалгаар “Оюуны Инноваци” төрийн бус байгууллагын судлаачид боловсрууллаа. Эдгээр судлаачид нь 2014 болон 2017 онд шүүхийн ажиглалтын арга зүйг нэвтрүүлэхэд хамтран, шинжээчээр ажилласан туршлагатай мэргэжилтнүүд юм.

Уг гарын авлагад шүүхийн ажиглалтын талаарх ерөнхий ойлголт болон шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглахад шаардлагатай зүйлүүд, бэлтгэл ажил, анхаарах асуудлуудыг товч, тодорхой оруулав. Мөн түүнчлэн шүүх хуралдааны нийтлэг дэг журам, шүүх хуралдааныг ажиглах арга барил, ажиглалтын үр дүнг баталгаажуулах зэрэг шүүхийн ажиглагчийн зайлшгүй мэдэж байх зүйлийг инфографик хэлбэрээр багтаасны сацуу хавсралтад шударга шүүхээр шүүлгэх эрхийн тухай ойлголт, эрүү, иргэн болон захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны талаарх анхан шатны мэдээлэл зэргийг нэгтгэн боловсруулж орууллаа.

Ажиглагч шүүх хурал эхлэхийн өмнө энэхүү гарын авлагатай танилцаж, ажиглалт хийхэд шаардлагатай мэдээлэл авахын хамт ажиглалтын явцад асуулгын хуудсыг алдаагүй бөглөх, баталгаажуулах дадлыг эзэмших, багаар ажиллах арга барилтай танилцах нь зүйтэй. Түүнчлэн ажиглалтын багийн ахлагч баг доторх

зохион байгуулалтыг хэрхэн хийх, ажиглалтын тайлангаа ямар арга зүйд үндэслэн боловсруулах талаар мэдэх боломжтой.

Шударга, хараат бус шүүхийг бий болгоход иргэний оролцоо, хяналт чухал тул энэхүү гарын авлагыг шүүх хуралдааны ажиглалт хийх сонирхолтой иргэд, байгууллагууд өргөнөөр ашиглахыг зөвлөе.

П. Эрдэнэжаргал
ННФ-ын Гүйцэтгэх захирал

1

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТ

1. ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ТУХАЙ

Шүүхийн ажиглалт нь шүүхийн мониторингийн нэг төрөл юм.

ШҮҮХИЙН МОНИТОРИНГ

Шүүхийн үйл ажиллагааны ил тод, шударга, бие даасан, хариуцлагатай, бүтээмжит байдлыг нэмэгдүүлэх ач холбогдолтой хүний эрхийн мониторингийн нэг хэлбэр.

ХҮНИЙ ЭРХИЙН МОНИТОРИНГ

Олон улсын хүний эрхийн стандартууд дотоодын нөхцөл байдалд (сонгууль, шүүх хуралдаан, жагсаал цуглаан г.м) хэрхэн хангагдаж байгааг үнэлэх хэрэгсэл юм.

Шүүхийн ажиглалтаар шүүхийн бие даасан хараат бус байдал, үйл ажиллагааны ил тод болон хариуцлагатай, бүтээмжтэй, шударга ёс тогтоож буй байдал зэрэгт мониторинг хийдэг.



БИЕ ДААСАН, ХАРААТ БУС БАЙДАЛ

Тодорхой хэрэг, маргааныг хэрхэн шийдэж байгааг ажиглахдаа бодит мэдээлэлд үндэслэдэг.



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

Шүүх хуралдааны явцыг хөндлөнгөөс ажиглах замаар мэдээлэл цуглуулах нэг хэлбэр бол Ажиглалт юм.



ХАРИУЦЛАГАТАЙ БҮТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

Ажиглалтаар шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад оролцогчийн мэдлэг, ур чадварыг үнэлэх боломж бүрддэг.



ШУДАРГА ЁС ТОГТООЖ БУЙ БАЙДАЛ

Ажиглалт хийснээр шүүх тогтолцооны үйл ажиллагааг өргөн хүрээнд дүгнэх боломж бүрддэг.

2. ШҮҮХИЙН АЖИГЛАГЧ БА ТҮҮНИЙ АЖИЛЛАХ ЗАРЧИМ


ШҮҮХИЙН АЖИГЛАГЧ ГЭЖ ХЭН БЭ?



Шүүх хуралдааны явцыг хөндлөнгөөс ажиглаж үнэн зөв, бодит мэдээлэл цуглуулах замаар оролцох субъект

- Эрүү, иргэн, захиргааны эрх зүйн мэдлэгтэй байх
- Хүний эрхийн талаар зохих ойлголттой байх
- Хараат бусаар ажиглалт хийх чадвартай байх

АЖИГЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗАРЧИМ



2

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТАД БЭЛТГЭХ

Хэргийн ангилал, шүүхийн шатлал, оролцогч буюу холбогдогчдын тоо, хэргийн төрөл зэрэг нарийвчилсан шалгуураар шүүх хуралдааныг сонгож болно. Жишээ нь, холбогдогчдын тоо гурваас дээшгүй, онц хүнд хэргээс бусад төрлийн хэргийг анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэх эрүүгийн хэргийн шүүх хуралдаанд ажиглалт хийх гэх мэт.


1. ШҮҮХ ХУРАЛДААНЫГ СОНГОХ

1 Шүүх хуралдааныг зөв сонгох нь ажиглалтыг амжилттай хэрэгжүүлэх чухал хүчин зүйлийн нэг.


2 Ажиглагч эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар ерөнхий ойлголттой байх.

3 Эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хамаарч шүүх хуралдаан бүр тус тусдаа онцлогтой болохыг анхаарах.


4 Ажиглалт явуулах шүүх хуралдааны товыг урьдчилан мэдэх.




Шүүх хуралдааныг сонгох шалгуур тавьсан нөхцөлд ажиглагч тухайн хэрэг, маргааны талаар суурь мэдээлэл олж авах шаардлагатай.



Ажиглагч нь эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн шүүх хуралдааны аль нэгийг сонгон ажиглалт хийнэ.



Эрүүгийн, иргэний, захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагааны талаар нэмэлт мэдээллийг гарын авлагын хавсралтаас дэлгэрүүлэн үзнэ үү.



Ямар хэргийн шүүх хуралдаанд ажиглалт хийх талаар судалж, шүүх хуралдааны товыг тэмдэглэж авах.

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОВЫГ ХААНААС МЭДЭХ ВЭ?

- www.shuukh.mn цахим хуудас
- тухайн шүүхийн өөрийн цахим хуудас
- шүүхийн хүлээлгийн танхим дахь мэдээллийн самбар
- шүүхийн олон нийттэй харилцах мэдээллийн ажилтнаас авах

ТОДРУУЛГА:


Шүүх хуралдааны талаар шүүхийн Тамгын газар болон шүүгчийн туслахаас мэдээллийг нарийвчлан тодруулах боломжтой. Аль болох олон хэрэгт ажиглалт хийвэл судалгааны хувьд давуу тал болно.

2. ШҮҮХ ХУРАЛДААНЫГ АЖИГЛАХ БЭЛТГЭЛ АЖИЛ

Шүүхийн ажиглалт эхлэхээс өмнө дараах бэлтгэл ажлууд хийгдсэн байна. Үүнд:

БАГ БҮРДҮҮЛЭХ

1 Ажиглалтын нарийвчлалыг сайжруулах үүднээс шүүх хуралдаан бүрд 2 ажиглагчаас бүрдсэн баг ажиллах.




Багаар ажиллах нь ажиглалтыг үнэн бодитой, үр дүнтэй болгоход чухал нөлөөтэй байдаг.

2 Нэг багт ажиллах хамтрагчид багадаа 7 хоног бүр солигдож бүрэлдэхүүнээ өөрчилж байх.



Ажиглалтын багийн гишүүдийг хооронд сэлгэх нь бусдадаа тавих хяналт, гүйцэтгэлийг сайжруулна.


3 Ажиглалтын баг ахлагчаа томилж ахлагч нь багийн дотоод зохион байгуулалтыг хариуцна.



Багийн ахлагч ажиглалт хийх хуваарь гаргах, шүүхийн зохион байгуулагчтай өдөр тутам харилцах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

ШҮҮХИЙН ТАЛААР СУУРЬ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

1 Ажиглалт хийх шүүхийн талаар суурь мэдээлэл цуглуулахаас ажиглалтын бэлтгэл ажил эхэлнэ.



Тухайн шүүхийн хаяг, байршил, шүүх рүү хэрхэн очих тухай мэдээлэл, нийтийн тээврийн чиглэл, маршрут зэргийг урьдчилж мэдэх.


2 Тухайн шүүхийн хүлээж авсан буюу шийдвэрлэж байгаа хэргийн тоо, ачаалал, статистик үзүүлэлтийг судлах.



Ажиглалтын хугацаанд хэдэн шүүх хуралдаанд ажиглалт хийх бодит боломжийг судлахад суурь мэдээлэл ач холбогдолтой байдаг.

ЦАГАА ТӨЛӨВЛӨХ

1 Шүүх хуралдаан болох цагийг урьдчилан мэдэж, хуралдаанд хоцрохгүй, цагтаа ирэх.



Ажиглагч шүүх хуралдаан эхлэх цагаас хамгийн багадаа 15 минутын өмнө шүүх дээр хүрэлцэн ирсэн байх.


2 Хурал эхлэхээс өмнө шүүхийн цагдаад бүртгүүлж, хуралдаан болох танхимаа олж, суудлаа эзэлсэн байх.



Зарим тохиолдолд хэргийн оролцогчдыг дагалдан олон хүн ирж суудал хүрэлцэхгүй болох магадлалтай болдгийг анхаарч аль болох эрт ирж, суудал эзлэх.

БИЕИЙН БАЙЦААЛТАА ШАЛГАХ


1 Шүүхийн байранд нэвтрэхэд ажиглагч өөрийгөө нотлох баримт бичгийг биедээ байнга авч явах.



Шүүхийн байранд нэвтрэхдээ иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх, гадаад паспортын аль нэгийг үзүүлж бүртгүүлэх.

ТЭМДЭГЛЭЛИЙН ДЭВТЭРТЭЙ БАЙХ


1 Ажиглагч бүр тэмдэглэл хөтлөх дэвтэр, үзэг, балтай байх.



Асуулгын хуудаст тэмдэглэж чадаагүй болон шүүх хуралдааны үйл ажиллагаатай холбоотой бусад мэдээллийг бичиж авах.

АСУУЛГЫН ХУУДАСТАЙ БАЙХ


1 Шүүхийн ажиглалтын багийн ахлагч нь ажиглагч бүрд хангалттай тооны асуулгын хуудас өгөх



Шүүх хуралдаанаас өмнө ажиглагч асуулгын хуудастай бүрэн гүйцэд танилцаж уншсан байх.

ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОХ БОЛОМЖГҮЙ ТАЛААР МЭДЭГДЭХ


1 Аливаа шалтгаанаар ажиглагч шүүх хуралдаанд сууж ажиглалт хийх боломжгүй болсон тохиолдолд урьдчилан мэдэгдэх.



Шүүх хуралдаанд оролцох боломжгүй ажиглагчийн оронд өөр ажиглагч томилох ажлыг багийн ахлагч хариуцан зохион байгуулна.


АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ БАЙХ

1 Тухайн хэрэгт ажиглагчийн хувийн ашиг сонирхол хөндөгдөж байгаа бол ажиглалт хийхээс татгалзах.



Ажиглагчийн гэр бүл, төрөл садан, найз нөхөд, хувийн харилцаатай этгээд холбогдсон хэрэг, маргаанд ажиглалт хийхээс татгалзана.

2 Ажиглагч ашиг сонирхлын зөрчил үүссэн гэж үзвэл нэн даруй ахлагчид мэдэгдэх.



Ашиг сонирхлын зөрчлийн улмаас ажиглагч шүүх хуралдаанд оролцох боломжгүй тохиолдолд ахлагч өөр гишүүн томилно.

3

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТ ХИЙХ

Өмнөх бүлэгт дурдсан бүх бэлтгэлийг хангасан ажиглагч шүүх хуралдааны үед дараах нийтлэг журмыг баримтлан ажиллана. Үүнд:

1. ШҮҮХ ХУРАЛДААНЫ НИЙТЛЭГ ЖУРАМ

1	2	3	4
ЖУРАМД ЗАХИРАГДАХ 	ХҮНДЭТГЭЛТЭЙ ХАНДАХ 	ДЭГ САХИХ 	СУУДЛААСАА БОСОХ 
Шүүх хуралдааны танхимд байгаа бүх хүн шүүхийг хүндэтгэх, тогтоосон журам, шүүгчийн шийдвэрт захирагдах	Шүүгч, шүүх бүрэлдэхүүн, хэргийн болон бусад оролцогчтой зөв боловсон, соёлтой харьцах	Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд шүүгч урьдчилан сануулах ба дахин зөрчил гаргавал танхимаас гаргана.	Шүүгч шүүх хуралдааны танхимд орж ирэх, оролцогч мэдүүлэг тайлбар өгөх, шүүхийн шийдвэр уншиж сонсгох үед танхимд байгаа бүх хүн суудлаасаа босно.




САНАМЖ:

- Ажиглагч шүүгчийн асуултад суудлаасаа босож хариулна.
- Иргэний болон захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нийтлэг нэг дэгээр явагдана.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дэг дараах онцлог зохицуулалтай:
 1. Анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанаар шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтооно.
 2. Гэм буруутай бол Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх, гэм буруугүй бол цагаатгах асуудлыг хянан шийдвэрлэнэ.
 3. Шүүх шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон шийдвэрийг шүүх хуралдааны танхимд танилцуулж, тэмдэглэлд тусгуулсны дараа түүнд Эрүүгийн хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна.

А. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ

Эрүүгийн хэргийн шүүх хуралдаан нь дараах дэгийн дагуу явагдана.



Б. ИРГЭН БОЛОН ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ДЭГ

1. ИРГЭНИЙ ХЭРЭГ
2. ЗАХИРГААНЫ ХЭРЭГ

Иргэн, захиргааны хэргийн шүүх хуралдаан нийтлэг нэг дэгээр явагддаг (ИХШХШТХ*-ийн 98-114 зүйл, ЗХШХШТХ**⁻ийн 89-111 зүйлийг дэлгэрүүлэн харна уу)

1. Шүүх хуралдааныг нээх
2. Шүүх хуралдааны ирц, оролцох эрхийг шалгах

10. Хэргийн оролцогчид мэтгэлцэх
11. Нотлох баримтыг шинжлэх, асуулт тавих дараалал

3. Оролцогч шүүх хуралдаанд ирээгүйгээс үүдэх үр дагавар
4. Орчуулагч, хэлмэрчийн үүргийг тайлбарлах

12. Гэрчийн мэдүүлэг сонсох
13. Бичмэл, цахим болон эд мөрийн баримтыг шинжлэх

5. Гэрчийг гаргах
6. Шүүх бүрэлдэхүүнийг зарлах ба татгалзан гаргах эрхийг тайлбарлах

14. Шинжээчийн дүгнэлт сонсох
15. Хэргийн оролцогчоос нэмж тодруулах

7. Хэргийн оролцогчийн эрх, үүргийг тайлбарлах
8. Хэргийн оролцогчоос гаргасан хүсэлтийг шийдвэрлэх
9. Хэрэг хэлэлцэж эхлэх

16. Иргэдийн төлөөлөгч дүгнэлт гаргах
17. Шүүх хуралдаан завсарлах
18. Шүүх бүрэлдэхүүн зөвлөлдөх тасалгаанд орох

*ИХШХШТХ – Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

**ЗХШХШТХ – Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

В. ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТАНХИМД ХОРИГЛОХ ЗҮЙЛ



шүүн таслах
ажиллагаанд оролцох,
шүүгчид хөндлөнгөөс
нөлөөлөх



гар утсаар ярих



дуу, дүрсний
бичлэг хийх



галт зэвсэг, зэвсгийн
чанартай эд зүйл
оруулах



шүүх хуралдаан
даргалагчийн
зөвшөөрөлгүй ярих



хүмүүсийн анхаарал
татахуйц том оврын зүйл
авч орох



Согтуурсан, мансуурсан
болон насанд хүрээгүй
хүн, 7 хүртэлх насны
хүүхэд оролцох



Шүүхийн хэлэлцүүлэгт
нөлөөлж, саад болохоор
үйл хөдлөл, зан авир
гаргах



Бохь заглах

Г. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ



- Шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс улсын яллагчаар оролцоно.
- Шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг шүүхийн өмнө нотлох үүрэг хүлээнэ.



- Иргэний хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шүүх хуралдаанд оролцоно.
- Шүүгдэгч оролцох шүүх хуралдаанд өмгөөлөгч заавал оролцоно.



- Ямар хэрэгт яллагдаж буйгаа мэдэх эрхтэй.
- Мэдүүлэг өгөх, өгөхөөс татгалзах эрхтэй.
- Өмгөөлөгчтэй харилцах, гомдол, хүсэлт гаргах эрхтэй.
- Анхан шатны шүүх хуралдаанд биечлэн оролцох үүрэгтэй.



- Хохирсон хууль ёсны эрх ашгаа хамгаалуулах эрхтэй.
- Учирсан хохирлоо нөхөн төлүүлэх хүсэлт гаргах эрхтэй.
- Мэдээллээр хангуулах эрхтэй.
- Аюулгүй байдлаа хамгаалуулах эрхтэй.



- Гэмт хэргийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлоо нөхөн төлүүлэх, сэргээлгэх хүсэлт гаргах эрхтэй.
- Иргэний нэхэмжлэгч гаргасан нэхэмжлэлээсээ татгалзах эрхтэй.



- Нэхэмжлэлийн талаар тайлбар гаргах эрхтэй.
- Баримт сэлт, хүсэлт гаргах эрхтэй.
- Шүүх хуралдаанд оролцох эрхтэй.



САНАМЖ:

Эрүүгийн хэргийн оролцогчдын эрх, үүргийн талаар 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3.3 дугаар зүйлээс 8.7 дугаар зүйлд тодорхой заасан байдаг тул дэлгэрүүлж харна уу.

Д. ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ



Шүүх хуралдаанд биечлэн оролцох, тайлбар гаргах, нотлох баримтаа заах замаар маргалдаж байгаа талтайгаа мэтгэлцэх эрхтэй.



Шүүгч, шүүхийн нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгч, шинжээч, хэлмэрчийг татгалзан гаргах хүсэлт гаргах эрхтэй.



Хэргийн материал, нотлох баримттай танилцах, нотлох баримт шинжлэн судлахад оролцох эрхтэй.



Нотлох баримт бүрдүүлэх, анхан шатны шүүхэд гарган өгөх эрхтэй.

- ✓ Анхан шатны шүүх
- х Давж заалдах шатны шүүх
- х Хяналтын шатны шүүх



Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой хүсэлт гаргах, бусад оролцогчид асуулт тавих эрхтэй.



Хуралдааны тэмдэглэлд 3 хоногийн дотор засвар оруулах, санал гаргах эрхтэй.



Шүүхийг хүндэтгэх, шүүх хуралдааны танхимд тогтоосон журмыг сахиу үүрэгтэй.



Шүүх хуралдааны товыг шүүхээс лавлах, товлосон цагт шүүх хуралдаанд хүрэлцэн ирэх үүрэгтэй.



Маргааныг шийдвэрлэхэд ач холбогдолтой нотлох баримтыг зааж хэлэлцүүлэх үүрэгтэй.



Бодит үнэнд нийцсэн тайлбар өгөх үүрэгтэй.



Оршин суугаа хаягаа өөрчилсөн бол шүүхэд мэдэгдэх үүрэгтэй.



Зохигч нотлох баримтыг шүүх хуралдаанаас өмнө өгсөн байх үүрэгтэй.

Е. ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ



ЭРХ

- Нэхэмжлэлээ өөрчлөх, ихэсгэх, багасгах, татгалзах, хариуцагчтай эвлэрэх;
- Нотлох баримт гаргаж өгөх, хэргийн материалтай танилцах;
- Шүүх хуралдаанд оролцох.

ҮҮРЭГ

- Шүүхийн дуудсанаар хүрэлцэн ирэх;
- Шүүх хуралдааны дэгийг сахих;
- Шүүхэд хэргийн талаар үнэн зөв тайлбар гаргах.




ЭРХ

- Нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөх, нэхэмжлэгчтэй эвлэрэх, татгалзах;
- Нотлох баримт гаргаж өгөх, хэргийн материалтай танилцах;
- Шүүх хуралдаанд оролцох.

ҮҮРЭГ

- Шүүхээс тогтоосон хугацаанд нэхэмжлэлийн талаар бичгээр тайлбар гаргах, шаардсан нотлох баримтыг гаргаж өгөх;
- Өөрөө болон төлөөлөгчөөрөө дамжуулан шүүх хуралдаанд оролцох.



ЭРХ

- Үүссэн маргааны талаар бие даасан шаардлага гаргасан, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тохиолдолд шүүх хуралдаанд оролцох;
- Хэргийн оролцогчийн адил эрх эдэлнэ.

ҮҮРЭГ

- Шүүх хуралдаанд оролцохгүй талаарх хүсэлтээ заавал бичгээр гаргах;
- Хэргийн оролцогчийн адил үүрэг хүлээнэ.



САНАМЖ:

Өмгөөлөгч нь захиргааны хэргийн бие даасан оролцогч биш бөгөөд зөвхөн төлөөлүүлж, өмгөөлүүлж байгаа хүний эрх, ашиг сонирхлыг илэрхийлэн хамгаална.

2. ШҮҮХ ХУРАЛДААНЫ ЯВЦ

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТАНХИМ



- 1 шүүгчдийн индэр
- 2 нарийн бичгийн даргын суудал
- 3 хэргийн оролцогчийн суудал
- 4 иргэдийн төлөөлөгчийн суудал
- 5 иргэдийн суудал

Ажиглагч нь иргэдийн суудалд сууна.

Ажиглагч шүүх хуралдааны үеэр иргэдийн суух хэсэгт, аль болох голын байрлалд суудал эзлэх нь зүйтэй. Шүүх хуралдаанд оролцогчдод ямар нэгэн байдлаар эргэлзээ төрүүлж, аль нэг талыг барьж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхгүйн тулд ийм суудал сонгох хэрэгтэй.



САНАМЖ:

Зарим шүүхийн байр, танхимын багтаамжаас хамаарч хуралдааны танхим нь иргэд суух зайгүй, эсхүл хүрэлцэхүйц суудалгүй байх нь элбэг тул шүүх хуралдааны танхимтай урьдчилан танилцах шаардлагатай.

ШҮҮХ ХУРАЛДААНЫ ХУГАЦАА

Ажиглалтын хугацаа буюу шүүх хуралдаан үргэлжлэх хугацааг урьдчилан хэлэх боломжгүй. Хэргийн нөхцөл байдал, оролцогч холбогдогчдын болон гэрч, шинжээчдийн тоо, нотлох баримт, хуралдааны үе шат гэх зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг. Иймд шүүх хуралдаан эхлэхийн өмнө хувийн бэлтгэлээ базааж, хурал удаан хугацаагаар үргэлжилж магадгүй гэж төлөвлөх нь зүйтэй.

АЖИГЛАХ АРГА БАРИЛ



Ажиглалт нь ярихгүйгээр сонсож, харснаа тэмдэглэх явдал юм. Ажиглагч харна, сонсоно, гэхдээ ярихгүй.

Ажиглагч аливаа хэлбэрээр шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй.

... САНАМЖ

Шүүгч, өмгөөлөгч, прокурорын үгэнд эсэргүүцэл, эсвэл дэмжлэг үзүүлсэн хөдөлгөөн, нүүрний хувирал гаргахаас болгоомжлох нь зүйтэй. Зүй зохисгүй зүйл ажигласан бол түүнийгээ бусдад анзаарагдахгүй байдлаар тэмдэглэлд тусгах хэрэгтэй.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ




Ажиглагч шүүх хуралдааны үеэр ажигласан бүх зүйлээ нарийн нягт тэмдэглэх шаардлагатай. Гэхдээ зөвхөн бодитоор ажиглагдсан зүйлээ тэмдэглэнэ.

... САНАМЖ

Өөрт төрсөн сэтгэгдэл, бодсон төсөөллөө асуулгын хуудаст бичихгүй бөгөөд тусад нь тайлан хэлбэрээр ирүүлнэ. Тэмдэглэл хөтлөхгүйгээр асуулга бөглөх боломжгүйг анхаарна уу.

СЭТГЭЛ ХӨДЛӨЛӨӨ ХЯНАХ



Шүүх хуралдааны туршид ямар нэг байдлаар сэтгэл хөдлөлөө илэрхийлэхээс зайлсхийж, сэтгэл хөдлөлөө хянах ёстой.

... САНАМЖ

Ажигласан хэргийн талаар үнэлэлт, дүгнэлт өгөх, үзэл бодлоо илэрхийлэхээс татгалзана. Энэ нь шүүхийн үйл ажиллагааны хараат бус, тасралтгүй байх зарчмыг хүндэтгэж байгаагаас гадна таны голч шударга, итгэл төрүүлэхүйц мэргэжлийн байдлыг илэрхийлэх үзүүлэлт болно.

АЖИГЛАГЧИЙН ЁС ЗҮЙ



Ажигласан хэргийн мэдээлэл, бодит байдлыг бусад этгээдэд задруулахгүй нууц хадгалах нь хамгийн чухал зарчим.

САНАМЖ

Ажигласан шүүх хуралдааны талаар ямар ч тохиолдолд хэвлэл мэдээлэл, цахим сүлжээгээр олон нийтийн өмнө ямарваа мэдэгдэл хийхийг хориглоно.

Аливаа бие даасан хэвлэлийн болон олон нийтийн өмнө мэдээлэл хийсэн тохиолдолд төслийн багаас хасаж, албан ёсоор гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

4

ШҮҮХИЙН АЖИГЛАЛТЫН ҮР ДҮНГ БАТАЛГААЖУУЛАХ

Шүүх хуралдааны ажиглалтыг бодитоор дүгнэж, үр дүнг баталгаажуулж, тайлан боловсруулахад асуулгын хуудсыг алдаагүй бөглөсөн байх шаардлагатай байдаг. Үүнд:

ТЭМДЭГЛЭЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ



Шүүх хуралдааны дараа ажиглагч өөрийн тэмдэглэлдээ дүн шинжилгээ хийж, тэмдэглэлээ бүрэн бичиж дуусгана.

Багийн гишүүд шүүх хуралдааны явцад хийсэн тэмдэглэлээ харьцуулан дүгнэж, нэгтгэнэ.



САНАМЖ

Аливаа асуудлаар зөрүүтэй мэдээлэл байгаа тохиолдолд ажиглагч нар харилцан ярилцаж, хамгийн зөв гэсэн хувилбараар асуулгын хуудсыг бөглөх, эс бөгөөс хоосон орхих (N/A) хэрэгтэй. Тааж бичиж болохгүй.

АСУУЛГЫН ХУУДАС БӨГЛӨХ

- 1 Асуулгын хуудсыг үнэн зөв, тодорхой ойлгомжтой, бүрэн гүйцэд бөглөх;
- 2 Шүүх хуралдаан хойшилсон тохиолдолд асуулгын эхний хэсгийг бөглөж, гарын үсэг зурж баталгаажуулах;
- 3 Шүүх хуралдаан бүрийг 2 хүн ажиглах бөгөөд дундаа нэг асуулгын хуудас бөглөх ба ажиглагчийн мэдээлэл хэсэгт ажиглагч өөрийн овог, нэрийг бичих;
- 4 Шүүх хуралдааны холбогдох мэдээллийг хуралдааны хуваариас авч, асуулгын хуудаст урьдчилан бичсэн байх;
- 5 Ажиглагчид тогтмол уулзалт хийж, зохион байгуулалтын болон арга зүйн зөвлөгөө авч байх;

- 6 Багийн ахлагч 14 хоног тутамд асуулгын хуудсыг хуви­лан эх хувийг шүүхийн ажиглалтыг зохион байгуулж буй хүнд хүргүүлж байх.



АНХААРАХ

Асуулгын хуудсын асуулт бүрийг бөглөж, тухайн шүүх хуралд хамааралгүй асуудалд (N/A) гэсэн тэмдэглэгээг хийж болно.

Асуулгын хуудсыг кодлох нь чухал бөгөөд цаашид мэдээллийг нэгтгэх явцад шинжээчид мэдээллийн сангаас тухайн ажиглалтын хуудсыг олж авах, нягтлах, шалгахад тус болдог. Кодыг ажиглалтын төслийн баг төслийн онцлогт тааруулан тогтоож болох бөгөөд ажиглалт хийсэн шүүхийн харьяалах аймаг, дүүргийн товчлол үсэг, огноо, нэмэлт дугаар гэх зэргээр тогтоох боломжтой.

АЖИГЛАЛТЫН ТАЙЛАН ГАРГАХ



Ажиглалт хийсэн нийт шүүх хуралдааны явцын тэмдэглэл болон ажиглалтын хуудсанд үндэслэн Ажиглагч тайлан гаргаж зохион байгуулагчид ирүүлнэ.



САНАМЖ

Тайлан, зөвлөмжид шүүгч, эсхүл прокурорыг онцолж шүүмжлэх, нэрийг нь дурдах зорилго агуулахгүй байх.

Гагцхүү хууль бус шийдвэр гаргаж, хүний эрхийг бүдүүлгээр зөрчсөн тохиолдолд холбогдох хариуцлага хүлээлгэх байгууллагад (шүүгчийн ёс зүйн хороо) мэдэгдэж болно.

ХАВСРАЛТ

ШУДАРГА ШҮҮХИЙН СТАНДАРТ

Хууль ёсны эрх ашиг зөрчигдсөн, эрх чөлөөгөө хязгаарлуулсан, эсхүл ямар нэгэн байдлаар эрх зөрчигдсөн тохиолдолд шударга шүүхээр шүүлгэх нь хүний үндсэн эрх юм. Энэхүү эрх нь Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1945 оны “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, 1966 оны “Иргэний болон улс төрийн эрхийн пакт”-д тусгалаа олж бүс нутгийн, олон улсын байгууллагуудын гэрээ, бусад баримт бичигт тусгагдаж, хүлээн зөвшөөрөгдсөн.

Шударгаар шүүлгэх эрхийн стандартад шүүхийн өмнө эрх тэгш байх; бие даасан хараат бус, шударга шүүхээр шүүлгэх; шүүх хуралдаан нээлттэй байх; гэм буруугүйд тооцогдох болон дуугүй байх; хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшилж сунжралгүйгээр шүүлгэх, өөрийгөө өмгөөлөх; эрх зүйн туслалцаа авах; нотлох баримт гаргаж өгөх, үнэлүүлэх; орчуулагч, хэлмэрч авах; шүүхийн шийдвэр үндэслэлтэй, хууль ёсны байх зэрэг стандартууд багтдаг.

А. Хууль, шүүхийн өмнө тэгш байх эрх

Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байж, хуулиар ямар ч алагчлалгүйгээр адилхан хамгаалуулах эрхтэй болохыг Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх энэхүү зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” хэмээн баталгаажуулсан.

Б. Бие даасан хараат бус, шударга шүүхээр шүүлгэх эрх

“Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангана гэдэг нь төрийн бусад эрх мэдэл (хууль тогтоох, гүйцэтгэх)-ээс шүүх эрх мэдлийг бүрэн тусгаарлаж, шүүгч чиг үүргээ зөвхөн хуульд нийцүүлэн

чөлөөтэй, айдасгүй, мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх хууль зүйн болон хувийн баталгааг бүрдүүлэх” /Н.Лүндэндорж. Төрийн онол. УБ., (2008), 228 дахь тал./-ийг хэлэх бөгөөд энэ нь шүүхээр хэрэг маргаанаа шийдүүлж байгаа иргэн, хуулийн этгээд “... шударга шүүхээр шүүлгэх...” үндсэн эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж чадах юм. Энэ зарчмын эрх зүйн үндсийг Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн 1-д “шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана” хэмээн баталгаажуулсан.

В. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим

Шүүх хуралдааныг нээлттэй явуулах нь шүүхийн бие даасан, шударга байх нэгэн чухал үзүүлэлт бөгөөд шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг бататгах хамгаалалт болдог. Зарим нэг онцгой тохиолдлоос бусад үед шүүх хуралдааныг нээлттэй явуулах ёстой. Шүүх хуралдааныг нээлттэй явуулах нь зөвхөн хэргийн талуудад хамаараад зогсохгүй олон нийтийн эрх ашигт нийцэх асуудал юм. Олон нийт шударга байдал хэрхэн тогтож байгаа, шүүх ямар шийдвэр гаргасан эсэхийг мэдэх эрхтэй.

Нээлттэй шүүх хуралдаанд ажиглагчаар оролцохыг хүссэн иргэн бүрийг ямар нэгэн зөвшөөрөл шаардахгүйгээр шүүх хуралдаанд оролцуулах, ингэхдээ шүүх хуралдааны аюулгүй байдлыг хангах үүднээс зөвхөн бичиг баримт, шаардлагатай тохиолдолд биедээ авч яваа эд зүйлийг нь шалгаж нэвтрүүлнэ. /ННФ.Шүүх хуралдааны ажиглалт судалгааны тайлан/. УБ., 2017, 11 дэх тал/

Г. Гэм буруугүйд тооцогдох болон дуугүй байх эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 4-т “өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, ...өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно...” гэж зааснаар хүний халдашгүй байх, гэм буруугүйд тооцогдох, шударга шүүхээр шүүлгэх үндсэн эрхийн үзэл санааг баталгаажуулжээ.

Гэм буруугүйд тооцох зарчим нь эрүүгийн хэргийн тухайд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх үед нэг талыг барих, урьдаас тогтсон хөдөлбөргүй үнэн гэх нотлох баримтад тулгуурлах явдлыг үгүйсгэн бусдыг үндэслэлгүйгээр яллагдагчаар татах, шүүхэд шилжүүлэхгүй, ял шийтгэл оногдуулахгүй байхын нэг чухал баталгаа мөн. /Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., (2000), 50 дахь тал./

Өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй буюу хэргээ албадан хүлээхгүй байх ба дуугүй байхтай холбогдсон эрхүүд нь гэм буруугүйд тооцогдох эрхээс урган гардаг. Яллах тал яллагдагчийн гэм бурууг нотлох үүрэгтэй бөгөөд түүний гэм бурууг гарцаагүй байдлаар нотолж чадахгүй бол яллагдагч гэм буруутан болохгүй.

Д. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулалгүй шүүлгэх эрх

Шүүн таслах ажиллагааг огт хойшлуулалгүйгээр явуулахыг хуулиар шууд зохицуулах боломжгүй. Харин шүүн таслах ажиллагааг үндэслэлгүйгээр хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хойшлуулахыг хориглодог.

Гэмт хэрэгт буруутгагдаж байгаа хүн, ялангуяа цагдан хоригдож байгаа хүн бүр боломжит хугацаанд хэргээ шалгуулах, шүүхээр хэлэлцүүлэх эрхтэй талаар Иргэний болон улсын төрийн эрхийн пактад заасан бөгөөд энэ нь хүний эрхэм чанар, халдашгүй, чөлөөтэй байх эрх, гэм буруугүйд тооцогдох зарчимтай холбогддог. Иймд эрх бүхий байгууллага нь шүүн таслах ажиллагааг аль болох боломжит богино хугацаанд явуулах үүрэгтэй. Нөгөөтэйгүүр, гэрчийн ой санамж арилах буюу мэдээллээ алдах, гэрч шүүх хуралдаанд оролцох боломжгүй болох, бусад нотлох баримт үгүй болох буюу арилах зэргээс сэргийлж, хүний өмгөөлөх эрхийг хэрэгжүүлэхийн тулд тодорхой хугацаанд байцаан шийтгэх ажиллагаа явуулдаг.

Е. Өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрх

Хүн бүр өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй бөгөөд өмгөөлөгчөө чөлөөтэй сонгож, төлбөр төлж хууль зүйн туслалцаа авч чадахгүй бол талуудын тэгш байдлыг хангах

үүднээс төрөөс томилсон мэргэжлийн өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авах эрхтэй байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14-т “Монгол Улсын иргэн “.. өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй...” хэмээн зааж өмгөөлүүлэх эрхийг хангах эрх зүйн үндсийг тогтоосон. Энэхүү эрхийг эдлэхэд дараах шаардлагууд хангагдсан байх ёстой. Үүнд:

- Энэ эрхийг үр нөлөөтэй хэрэгжүүлэхийн тулд шүүн таслах ажиллагаа явагдахаас өмнө өмгөөлөх талд тодорхой хугацааны өмнө мэдэгдсэн байх.
- Өмгөөлөгч болон иргэний хооронд харилцан итгэлцэл бүрдүүлэх үүднээс иргэн ямар өмгөөлөгч авахаа өөрөө шийдэх.
- Иргэн болон өмгөөлөгч нарын хоорондын харилцаа нь нууцлалтай байх.
- Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийнхээ эрх, эрх ашгийг хамгаалахад шаардлагатай бүхий л боломжит гарцыг хуулийн хүрээнд тайлбарлаж, шүүх дээр эрхийг нь хамгаалахад туслах үүрэгтэй байх.
- Өмгөөлөгчдийг айлган сүрдүүлэх буюу мэргэжлийнхээ дагуу ажиллаж буй өмгөөлөгчийн үйл хэрэгт хөндлөнгөөс оролцохыг хориглох.

Ё. Орчуулагч, хэлмэрч авах эрх

Монгол хэл мэдэхгүй, эсхүл ярих чадварын хувьд хөгжлийн бэрхшээлтэй бол мэргэшсэн орчуулагч, хэлмэрчийн туслалцааг авах эрхтэй. Өөрөөр хэлбэл, шүүн таслах ажиллагаа явуулж буй хэлийг мэдэхгүй, ойлгохгүй бол түүнд ойлгомжтой, зөв аман болон бичгийн орчуулга хийж өгөх, хэл ярианы бэрхшээлтэй бол хэлмэрч авах нь хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчмыг хэрэгжүүлэх, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хангахад чухал нөлөө үзүүлдэг.

Ж. Шүүхийн шийдвэр үндэслэлтэй байх

Шүүхийн шийдвэрийн үндэслэл нь иргэний давж заалдах эрхийн гол үндэс болдог. Тиймээс шүүхийн шийдвэр нь хэргийн бодит байдал хийгээд түүнийг нотлох хуульд заасан арга хэрэгслээр цуглуулсан, хэрэгт авагдсан, шүүх хуралдааны үеэр хэлэлцэгдэж, шинжлэн судлагдсан нотлох баримтад үндэслэн гарах бөгөөд үүнийг шүүхийн шийдвэрийн үндэслэлтэй байдал гэж ойлгоно.

Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл давж заалдах эрхтэй талаар шүүх хуралдаан даргалагч шүүх хуралдаанд оролцогчдод тайлбарлаж өгөх үүрэгтэй.

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА

Эрүүгийн хэргийн шүүхийн ажиллагаа нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хариуцлагатай хэсэг байдаг. Гэмт хэргийг мөрдөн шалгаж, прокурор хяналтаа тавьж, яллагдагчаар татагдсан этгээдийн гэм бурууг шүүхээр эцэслэн тогтоолгох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр прокуророос гэмт хэргийн хавтаст хэргийг шүүхэд шилжүүлдэг.

Үе шатууд:

1. Прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийг шүүх хүлээн авснаар эрүүгийн хэргийн шүүхийн ажиллагаа эхэлдэг. Гэхдээ хэргийг шүүхэд шилжүүлэхээс өмнө яллагдагчийг цагдан хорих эсэх шийдвэр гаргах, гэмт хэргийг илрүүлэх, гэрч, хохирогчийг хамгаалах зэргээр эрүүгийн хэргийг шалгах ажиллагаанд шүүх хяналтаа тавьж оролцдог. Учир нь шүүх эрүүгийн хэрэгт холбогдсон буюу хохирсон хүний эрхийн зөрчлийг эцэслэн хянаж, шийдвэрлэдэг.
2. Шүүхээс яллагдагчийг шүүхэд шилжүүлсний дараа шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулна. Урьдчилсан хэлэлцүүлэгт оролцогчдын санал, хүсэлт, гомдол, хохирлын асуудал, шүүх хуралдааны тов, хуралдааныг хаалттай явуулах эсэх, хэргийн бусад асуудлыг хэлэлцдэг.
3. Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх анхан шатны шүүх хуралдаан хоёр хэсэгтэй. Үүнд:
 - а. Шүүгдэгч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай эсэхийг тогтооно.
 - б. Гэм буруутай гэж үзсэн бол шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг хэлэлцэх шүүх хуралдааныг үргэлжлүүлэн явуулна.

Гэм буруугүй бол цагаатгах асуудлыг хянан шийдвэрлэнэ. Мөн шүүх гэмт хэргийн улмаас учирсан хохирлын асуудлыг хэлэлцдэг. Шүүх хуралдааныг өдрийн цагаар явуулах ба амрах зайлшгүй шаардлагатайгаас бусад цагт тасралтгүй явуулна.

Шүцх хуралдааныг дараах тохиолдолд бцхэлд нь, эсхцл зарим хэсгийг хаалттай явуулна:

- Төр, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой хэргийг хянан шийдвэрлэх;
- Өсвөр насны шүүгдэгчид холбогдох хэргийг хянан шийдвэрлэхэд түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсэлт гаргасан бол;
- Арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай гэж үзвэл түүнд холбогдох хэргийг хянан шийдвэрлэх;
- Хамгаалалтад байгаа гэрчийн мэдүүлгийг уншиж сонсох, эрэн сурвалжлах нууц ажиллагаа, мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад олж авсан нотлох баримтыг шинжлэн судлах;
- Хаалттай явуулах шүүх хуралдаанд оролцуулах, байлцуулах хүнийг шүүх шийдвэрлэнэ.

Шүүх нотлох баримтаар тогтоогдсон хэргийн нөхцөл байдлыг үндэслэн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчилж болно.

Шүцх дараах үндэслэлээр шүцх хуралдааныг тодорхой хугацаагаар завсарлуулж болно:

- Ажлын цаг дууссан;
- Төлөөлөн мэтгэлцэж байгаа улсын яллагч бусад улсын яллагчтай, өмгөөлөгч бусад өмгөөлөгчтэй зөвлөлдөх тухай хүсэлт гаргасан;
- Гэм буруугийн талаар санал, хүсэлт гаргасан;
- Бусад хүндэтгэн үзэх шалтгаан байгаа бол.

Шүцх дараах үндэслэлээр шүцх хуралдааныг хойшлуулж болно:

- Шүүх хуралдаанд оролцвол зохих тал, хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, гэрч, шинжээч ирээгүй;
- Шүүх хуралдаанд нэмэлт шинжилгээ хийлгэх, туршилт хийх, газар, орон байранд үзлэг хийхийг талууд харилцан зөвшөөрсөн;

- Улсын яллагч, өмгөөлөгч солигдож, эсхүл нэмэгдэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох болсон;
- Шүүх хуралдааныг хойшлуулах хүндэтгэн үзэх бусад шалтгаан бий болсон.

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА

Иргэний хэргийн шүүхийн ажиллагаа эрүүгийн хэргээс ялгаатай нь иргэд хоорондын маргааныг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаа гэдгээрээ онцлогтой. Өөрөөр хэлбэл, иргэн шүүхэд хандахаас өмнө төрийн албан тушаалтан, өөр бусад байгууллага хэргийг урьдчилан шалгах ажиллагаа явуулдаггүй, гагцхүү шүүх бүх ажиллагааг хийдэг. Харин хуульд тусгайлан заасан зарим төрлийн маргааныг шүүхийн өмнөх урьдчилан шийдвэрлэх шатаар заавал дамжсан байхыг шаардана. Тухайлбал, хөдөлмөрийн маргаан таслах зөвлөлөөр шийдвэрлэгдэх хөдөлмөрийн маргаан, эвлэрүүлэн зуучлалд заавал хандахаар заасан гэр бүлийн харилцаанаас үүссэн маргааныг шүүхээс гадуур урьдчилан шийдвэрлэх ажиллагаагаар хянан шийдвэрлэсний дараа шүүхээр шийдвэрлэдэг. Харин эвлэрүүлэн зуучлалын бусад ажиллагааг шүүхийн урьдчилан шийдвэрлэх ажиллагаа гэж үздэггүй.

Эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн иргэн нэхэмжлэлээ шүүхэд хандан гаргаж, шүүх иргэний хэрэг үүсгэснээр эхэлж, шүүхээс нэхэмжлэл буюу хэргийг эцэслэн шийдвэрлэснээр иргэний хэргийн шүүхийн ажиллагаа дуусгавар болно. Хуульд зааснаар анхан шатны шүүхэд иргэний хэргийг хянан шийдвэрлэх хугацаа 60 хоног, нэг удаа 30 хоногоор сунгахаар заасан байдаг ч хэргийн онцлог, ээдрээ төвөгтэй байдал, шүүхийн ажиллагаа, нотлох баримттай холбоотой асуудал зэргээс шалтгаалж үүнээс удаан хугацаанд хянан шийдвэрлэгдэх тохиолдол гардаг. Хэргийн оролцогчийн хувьд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээд уг ажиллагаанд оролцдог. Мөн шүүх хуралдааны оролцогчоор хэргийн оролцогч, шинжээч, гэрч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгч оролцдог. Ажиглагч нь шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглахдаа иргэний төлөөлөл байдлаар хуралд оролцоно. Шүүх өөрийн санаачилгаар бус хэргийн оролцогчийн хүсэлт, санаачилгаар нотлох баримт бүрдүүлэх, цуглуулах ажиллагааг хийдгээрээ онцлог юм. Эрүү ба захиргааны хэрэг дээр шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг хийдэг бол иргэний хэрэг дээр урьдчилсан хэлэлцүүлэг хийдэггүй. Шүүх нотлох баримт бүрэн бүрдсэн гэж үзвэл хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх захирамж гаргаж хуралдааныг хийдэг. Хэргийн нотлох баримт, эсхүл үйл явдал нь төр,

байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчдын хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулна. Бусад бүх хуралдаан нээлттэй явагдана.

ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН АЖИЛЛАГАА

Төр буюу нийтийн захиргааны байгууллагаас иргэний эрхэд халдсан үйлдэл, эс үйлдэхүй гаргах тохиолдол цөөнгүй байдаг. Захиргааны байгууллагын үйл ажиллагаа, дур зоргыг хязгаарлах гол механизм бол иргэн хүн захиргааны хууль бус үйл ажиллагаа, шийдвэрийг захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргах замаар хянуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх, хууль бус шийдвэрийг хүчингүй болгуулах ажиллагаа юм.

Иргэний хэргийн маргаанаас ялгаатай нь төр иргэн хоёрын хооронд үүссэн нийтийн эрх зүйн хүрээний маргааныг захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэдэг. Захиргааны хэргийн шүүхийн ажиллагааны онцлог нь шүүх өөрийн санаачилгаар нотлох баримт бүрдүүлж, цуглуулж, шүүхийн мөрдөн шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Мөн хуульд шүүхэд шууд хандахаар зааснаас бусад захиргааны бүх маргаанд заавал шүүхийн өмнөх гомдлыг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа хийсэн байхыг шаарддаг. Гомдлыг урьдчилан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн шийдвэр, үйлдэл, эс үйлдэхүй гаргасан захиргааны байгууллага, албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтанд хандан гомдол гаргаж, шийдвэрлүүлэх байдлаар хэрэгждэгээрээ онцлог юм.

Хэргийн оролцогчийг

- Нэхэмжлэгч
- Хариуцагч
- Гуравдагч этгээд гэж ангилдаг.

Харин шүүх хуралдааны оролцогчийг хэргийн болон бусад оролцогч гэж ангилна. Үүнд:

- Хэргийн оролцогчийн төлөөлөгч
- Өмгөөлөгч
- Шинжээч
- Орчуулагч, хэлмэрч
- Иргэдийн төлөөлөгч
- Гэрч
- Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга.

Ажиглагч нь шүүх хуралдааныг хөндлөнгөөс ажиглах иргэний төлөөлөл байдлаар хуралд оролцоно.

Хэргийн нотлох баримт, эсхүл үйл явдал төр, байгууллага, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчийн хүсэлтээр шүүх хуралдааныг бүрэн буюу түүний зарим ажиллагааг хаалттай явуулж, бусад бүх хуралдаан нээлттэй явагддагаараа иргэний хэргийн шүүхийн ажиллагаатай ижил төстэй. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр хэрэгжүүлж, энэ зарчим хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд хэрэгжинэ.

Шүүх хуралдааныг товлон зарлахдаа шүүхийн урьдчилсан хэлэлцүүлэг явуулах ба урьдчилсан хэлэлцүүлгээр дараах асуудлыг хянан хэлэлцэнэ. Үүнд:

- Нотлох баримт хасуулах;
- Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх;
- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс урьдчилсан хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудал.

Шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгээр нэхэмжлэлийн шаардлагатай холбоотой асуудлыг хэлэлцэхгүй, харин шүүх хуралдаанаар хэлэлцдэг.

ШҮҮХ ХУРАЛДААНЫ АЖИГЛАЛТЫН ЖИШИГ ХУУДАС

КОД

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ажиглагчдын мэдээлэл:

1. _____
2. _____

А. Шүүх хуралдааны ерөнхий мэдээлэл:

1. Шүүхийн ажиглалтын огноо: _____
2. Шүүххуралдааныхуваарьтцаг: _____
3. Шүүх хуралдаан эхэлсэн цаг: _____
4. Шүүххуралдаандууссанцаг: _____
5. Шүүх хуралдаан хуваарьт цагаасаа хоцорч эхэлсэн бол шалтгааныг бичнэ үү.

6. Шүүх хуралдаан хойшилсон эсэх: Тийм Үгүй

7. Шүүх хуралдаан хойшлогдсон бол хэнээс болж хойшлогдсон, шалтгааныг бичнэ үү.

- а) шүүгч
- б) улсын яллагч
- в) шүүгдэгч
- г) шүүгдэгчийн өмгөөлөгч
- д) хохирогч
- е) хохирогчийн өмгөөлөгч
- ё) иргэдийн төлөөлөгч
- з) бусад оролцогч

¹ Шүүх хуралдааны ажиглалтын жишиг хуудас

Шалтгаан: _____

8. Талуудаас шүүх хуралдааныг хойшлуулах хүсэлт гаргасан байдал:

- а) утсаар
- б) бичгээр
- в) амаар
- г) тодорхойгүй

9. Эрүүгийн хэргийн зүйлчлэл: _____

10. Шүүх бүрэлдэхүүн (доорх хариултаас сонгож тэмдэглэнэ үү):

- а) Шүүгч дангаар
- б) Шүүх бүрэлдэхүүн

11. Шүүх хуралдааны даргалагчийн овог, нэр:

Шүүгчийн овог, нэр _____

Шүүгчийн овог, нэр _____

12. Шүүгдэгчийн талаарх мэдээлэл:

Овог, нэр: _____

Иргэний харьяалал: _____

Овог нэр: _____

Иргэний харьяалал: _____

Овог нэр: _____

Иргэний харьяалал: _____

13. Улсын яллагчийн овог, нэр:

ШУДАРГА ШҮҮХИЙН СТАНДАРТ

А. Шүүх хуралдааны нээлттэй байдал

1. Шүүх хуралдааны танхимд нэвтэрсэн байдал:
 - а) ямар ч саадгүй нэвтэрсэн
 - б) биеийн байцаалт шалгаж оруулсан
 - в) оруулахаас татгалзсан, шалтгаан: _____Хэн: _____

2. Шүүх хуралдаан нээлттэй журмаар явагдсан уу?
 Тийм Үгүй

3. Шүүгч нээлттэй зарлагдсан шүүх хуралдааныг хаалттай явуулахаар шийдвэрлэсэн үү?
 Тийм Үгүй

4. Тиймболшалтгаан: _____

5. Нээлттэй шүүх хуралдаанд оролцох хүсэлтэй бусад хүмүүсийг оруулсан уу?
 Тийм Үгүй

6. Үгүйбол ямар шалтгаанаар: _____

7. Нээлттэй шүүх хуралдаанд оролцоход зөвшөөрөл авсан уу?
 Тийм Үгүй

8. Тийм бол хэнээс?
 - а) шүүгч
 - б) шүүгчийн туслах
 - в) шүүх хуралдааны нарийн бичгийн дарга
 - г) шүүхийн хуяг
 - д) шүүхийн захиргааны бусад ажилтан

9. Шүүх хуралдаанд оролцогчдын зүгээс таныг нээлттэй шүүх хуралдаанд оролцуулахаас татгалзсан уу?

Тийм Үгүй

10. Тийм бол хэн:

- а) шүүгч
- б) улсын яллагч
- в) өмгөөлөгч
- г) хохирогч
- д) шүүгдэгч

Б. Хараат бус, бие даасан, шударга шүүхээр шүүлгэх эрх

1. Шүүх бүрэлдэхүүнийг татгалзан гаргах эрхийг шүүгч тайлбарлаж өгсөн үү?

Тийм Үгүй

2. Доорх этгээдүүдийг татгалзан гаргах хүсэлт тавьсан уу?

а) Даргалагч шүүгч

Тийм Үгүй

б) Бүрэлдэхүүнд орсон шүүгч

Тийм Үгүй

в) Бусад этгээд

Тийм Үгүй

3. Хэрэв тийм бол хүсэлтийг биелүүлсэн үү?

Тийм Үгүй

4. Шүүгч хэргийг алагчлалгүй шийдвэрлэсэн эсэхэд эргэлзээ төрсөн үү?

Тийм Үгүй

Тийм бол яагаад: _____

5. Шүүгдэгчийн эрх, үүргийг сануулсан эсэх: (сануулаагүй бол эрхийн өмнөх тоог дугуйлах)
1. Ямар хэрэгт яллагдаж байгаагаа мэдэх
 2. Яллах дүгнэлттэй танилцах
 3. Өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч авах
 4. Өмгөөлөгчтэйгөө ганцаарчлан уулзах
 5. Мэдүүлэг өгөх, өгөхөөс татгалзах
 6. Нотлох баримт гаргаж өгөх болон шалгуулах
 7. Хэргийн материалтай танилцах
 8. Шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцах, тэмдэглэлд засвар, өөрчлөлт оруулах хүсэлт гаргах
 9. Шүүх хуралдаанд оролцох
 10. Шүүх хуралдааны оролцогчийг татгалзан гаргах
 11. ЭБША-ны талаар гомдол гаргах
 12. Шинжээчийн дүгнэлттэй танилцах
 13. Эх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч хэлмэрч авах
 14. Шүүх хуралдаанд эцсийн үг хэлэх
 15. Шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах
 16. Өөрийн эсрэг мэдүүлэг өгөх болон гэм буруутай эсэхээ нотлох үүрэг хүлээхгүй байх
 17. Шүүхээс дуудсан цагт ирэх үүрэгтэй
 18. Шүүх хуралдааны дэгийг сахих үүрэгтэй
6. Шүүгч шүүх хуралдааны оролцогчдын эрх, үүргийг ойлгомжтой байдлаар тайлбарлаж өгсөн үү?
- Тийм Үгүй
7. Яллагчийн уншиж сонгосон яллах дүгнэлт шүүгдэгчийн гардаж авсантай таарч байгааг тодруулсан уу?
- Тийм Үгүй
8. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүх хуралдааны үеэр талууд идэвхтэй мэтгэлцсэн үү?
- Тийм Үгүй

9. Шүүгч хэлэлцүүлгийн үеэр шүүх хуралдааны танхимыг түр орхин гарсан уу?

Тийм Үгүй

10. Шүүгчийн анхаарал төвлөрөл сайн байсан уу?

Тийм Үгүй

11. Үгүй бол: (10-р асуултад “Үгүй” гэж хариулсан бол бөглөнө)

а) хоорондоо ярилцах

б) гар утсаа ашиглах

в) сонин, сэтгүүл унших

г) бусадхэлбэрээр _____

12. Шүүгчид зөвлөлдөх тасалгаанд шийдвэр гаргах үед зөвлөлдөх тасалгаанд өөр хүн орсон уу?

Тийм Үгүй

13. Тийм бол тодорхойлно уу?

В. Гэм буруугүйд тооцогдох, гэм бурууг хүчээр хүлээлгэхээс ангид байх, өөрийнхөө болон гэр бүлийнхээ гишүүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх

1. Шүүгдэгчийг гэм буруутай мэтээр сэтгэгдэл төрүүлсэн, ямарваа шинж тэмдэг байсан уу?

а) үсийг нь хуссан

б) хоригдлын дүрэмт хувцас өмсүүлсэн

в) шинж тэмдэг илрээгүй

2. Улсын яллагчтай харьцуулахад өмгөөлөх тал хүчин чадал сул байсан уу?

Тийм Үгүй

3. Улсын яллагч шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж илт буруутгаж харьцсан уу?

Тийм Үгүй

4. Шүүгч шүүхийн хэлэлцүүлгийн үеэр шүүгдэгчийг ёс суртахууны хувьд дорд үзэж, илт буруутгаж харьцсан уу?

Тийм Үгүй

5. Шүүгч шүүгдэгчид өөрийнхөө эсрэг болон гэр бүлийн гишүүнийхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь тайлбарлаж өгсөн үү?

Тийм Үгүй

6. Шүүгдэгч өөрийн эсрэг мэдүүлэг өгөхөөс татгалзсан уу?

Тийм Үгүй

7. Шүүгч шүүгдэгчийг асуултад хариулах үүрэггүй болон асуултад хариулахаас татгалзах нь өөрийнх нь эсрэг ашиглагдахгүй болохыг шүүгдэгчид тайлбарлаж өгсөн үү?

Тийм Үгүй

8. Шүүгч шүүгдэгчид гэм бурууг нь хүлээлгэхээр дарамталсан уу?

Тийм Үгүй

9. Шүүгч шүүх хуралдааныг хурдан дуусгахаар хичээж байсан уу?

Тийм Үгүй

10. Хэрэв тийм бол, хэрхэн, яаж? _____

Г. Нотлох баримт гаргах, үнэлүүлэх эрх

1. Шүүгдэгчийг мэдүүлэг өгч байхад нь ямар нэгэн байдлаар тасалдуулсан уу?

Тийм Үгүй

2. Хэрэв тийм бол, хэн, хэрхэн?

3. Нотлох баримтыг ямар хэлбэрээр танилцуулсан бэ? (1-ээс дээш хариулт сонгож болно)

- а) Бичгийн нотлох баримтыг гаргаж үзүүлэх хэлбэрээр
- б) Гэрчийн мэдүүлгийг уншиж сонгох хэлбэрээр
- в) Шинжээчийн дүгнэлтийг уншиж сонгох хэлбэрээр
- г) Гэрч, шинжээчийг шүүх хуралдаанд оролцуулж мэдүүлэг авах хэлбэрээр
- д) Дуу, дүрс бичлэг үзүүлэх хэлбэрээр
- е) Бусад хэлбэрээр

4. Дуу, дүрс бичлэгээр үзүүлэх нотлох баримтыг бүрэн, тодорхой үзүүлэх боломж, нөхцөл хангагдсан байсан уу?

- Тийм Үгүй

5. Шүүх хуралдаанд яллах талын гэрч оролцсон уу?

- Тийм Үгүй

6. Шүүх хуралдаанд цагаатгах талын гэрч оролцсон уу?

- Тийм Үгүй

5, 6-р асуултад Үгүй гэж хариулсан бол дараагийн асуултуудыг алгасан шууд 13-р асуултад хариулна уу.

7. Гэрчээс мэдүүлэг авах хүртэл түүнийг шүүх хуралдааны танхимаас гаргасан уу?

- Тийм Үгүй

8. Шүүгч гэрчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн үү?

- Тийм Үгүй

9. Шүүгч гэрчид худал мэдүүлэг өгвөл эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг сануулсан уу?

- Тийм Үгүй

10. Шүүх хуралдааны оролцогчдын зүгээс гэрчээс мэдүүлэг авахад сэтгэл зүйн болон бусад дарамт үзүүлсэн үү?

Тийм Үгүй

11. Шүүх хуралдааны үеэр өгсөн гэрчийн мэдүүлэг мөрдөн байцаалтын явцад өгсөн мэдүүлэгтэй нь зөрсөн үү?

Тийм Үгүй

12. Тийм бол зөрүүнд хэн, ямар тайлбар хийсэн бэ?

13. Шүүх хуралдаанд шинжээч оролцсон уу?

Тийм Үгүй

13-р асуултад Үгүй гэж хариулсан бол дараагийн асуултаудыг алгасан шууд 18-р асуултад хариулна уу.

14. Шүүгч шинжээчид эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн үү?

Тийм Үгүй

15. Шүүх хуралдааны үеэр шинжээчээс мэдүүлэг авсан уу?

Тийм Үгүй

16. Тийм бол хэний санаачилгаар?

17. Шүүгч шүүгдэгчид шинжээчийг татгалзах эрхийг нь тайлбарлаж өгсөн үү?

Тийм Үгүй

18. Шинжээчийн дүгнэлтийг хэлэлцсэний дараа нэмэлт болон дахин шинжилгээ хийлгэх асуудлаар хэргийн оролцогчид хүсэлт гаргасан уу?

Тийм Үгүй

19. Нотлох баримтаа дэмжих ямар нэгэн нэмэлт санал байгаа эсэх талаар шүүгч талуудаас асуусан уу?

Тийм Үгүй

20. Мөрдөн байцаалтын үеэр шүүгдэгчид сэтгэлзүйн болон бие махбодын дарамт учруулсан (албадлага), эрүү шүүлт хэрэглэсэн, хэрцгий харьцсан, заналхийлсэн, хууран мэхлэх болон бусад хууль бус арга хэрэгслийг ашигласан (доогуур нь зурах) хэмээн шүүгдэгч өмнө өгсөн мэдүүлгээсээ буцсан уу?

Тийм Үгүй

Д. Талуудын тэгш байдал

1. Улсын яллагч болон өмгөөлөгч шүүх хуралдаанд тэгш эрхтэй оролцсон уу?

Тийм Үгүй

Үгүй бол бичнэ үү. _____

2. Шүүгч шүүх хуралдааны оролцогчийн аль нэг талд давуу байдал олгосон үйлдэл гаргасан уу?

Тийм Үгүй

Тийм бол бичнэ үү. _____

3. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд улсын яллагчийн зүгээс ялын дүгнэлтийг өөрчлөх санал гаргасан уу?

Тийм Үгүй

4. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд өмгөөлөгчийн зүгээс ялын асуудлаар санал гаргасан уу?

Тийм Үгүй

5. Талуудад хэлэлцүүлгийн шатанд үг хэлэхийг зөвшөөрсөн үү?

Тийм Үгүй

6. Шүүгч шүүгдэгчийг эцсийн үгээ хэлэхэд нь саад хийсэн үү?

Тийм Үгүй

Е. Өөрийгөө өмгөөлөх, эрх зүйн туслалцаа авах эрх

1. Шүүх хуралдаанд шүүгдэгчийн өмгөөлөгч оролцсон уу?

Тийм Үгүй

2. Өмгөөлөгчийн овог нэр: _____

Өмгөөлөгчийн овог нэр: _____

Өмгөөлөгчийн овог нэр: _____

3. Шүүгдэгч өмгөөлөгчөө өөрөө сонгож, гэрээлж авсан уу?

Тийм Үгүй

4. Шүүгдэгч төрөөс томилогдсон өмгөөлөгч (улсын өмгөөлөгч) авсан уу?

Тийм Үгүй

5. Шүүх хуралдаанд хохирогч оролцсон уу?

Тийм Үгүй

6. Шүүх хуралдаанд хохирогчийн өмгөөлөгч оролцсон уу?

Тийм Үгүй

7. Өмгөөлөгчийн овог нэр: _____

8. Шүүгч шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхээ эдлэх хүсэлтэй байхад уг эрхийг нь эдлүүлээгүй, хязгаарласан уу?

Тийм Үгүй

9. Хэрэв тийм бол тодорхойлно уу? _____

10. Шүүх хуралдааны үеэр шүүгдэгчийн өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчтэй харилцаж байсан харилцааны хэв маягийг тодорхойлно уу?

- а) хэвийн
- б) хүйтэн, дээрэнгүй
- в) үл тоомсорлосон
- г) огт харьцаагүй
- д) мэдэхгүй

11. Шүүх хуралдааны үеэр өмгөөлөгч шүүгдэгчтэй харилцах боломжийг тодорхойлно уу?

- а) харилцах боломжтой зэрэгцэж суусан байсан
- б) харилцан ярилцах боломжгүй байсан
- в) харилцах боломж хязгаарлагдмал байсан
- г) харилцахыг даргалагч шүүгч хориглож байсан
- д) хурлын дэгд захирагдахыг шаардаж байсан

12. Шүүгдэгч өмгөөлөгчөөсөө татгалзах хүсэлт гаргасан уу?

- Тийм Үгүй

Тийм бол ямар үндэслэлээр: _____

13. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалыг хангалттай сайн судалж, танилцсан байсан уу?

- Тийм Үгүй

14. Шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд оролцохдоо хэргийн материалыг хуулбарлаж авсан байсан уу?

- Тийм Үгүй

15. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүгдэгчийн өмгөөлөгч шүүх хуралдаанд идэвхтэй мэтгэлцэж оролцсон уу?

Тийм Үгүй

Ё. Орчуулагч, хэлмэрч авах эрх

1. Шүүх хуралдаанд орчуулагч оролцсон уу?

Тийм Үгүй

Тийм бол хэний орчуулагчаар:

а) Шүүгдэгч

б) Хохирогч

в) Гэрч

2. Шүүгдэгч орчуулагч/ хэлмэрч авах хүсэлт гаргасан уу?

Тийм Үгүй

3. Хүсэлтийг хангасан уу?

Тийм Үгүй

Ямархэлээр: _____

4. Шүүх хуралдаанд дохионы хэлний хэлмэрч оролцсон уу?

Тийм Үгүй

Тийм бол хэний хэлмэрчээр:

а) Шүүгдэгч

б) Хохирогч

в) Гэрч

5. Орчуулагч, хэлмэрчийн эрх, үүргийг шүүгч тайлбарлаж өгсөн үү

Тийм Үгүй

6. Худал орчуулсан, хэлмэрчилсэн тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар орчуулагч/хэлмэрчид сануулсан уу?

Тийм Үгүй

7. Талуудад орчуулагч/хэлмэрчийг татгалзан гаргах эрхийг нь тайлбарлаж өгсөн үү?

Тийм Үгүй

8. Хуулийн дагуу өмгөөлөгчид гардуулан өгөх ёстой, шүүхийн баримт бичгүүдийн орчуулгын бичмэл хувийг шүүх хуралдааны явцад шүүгдэгчид өгсөн үү?

Тийм Үгүй

Ж. Шүүхийн шийдвэр

1. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны тэмдэглэлийг ямар хэлбэрээр хөтөлсөн бэ? (1-ээс дээш хариулт сонгож болно)

- а) Гараар бичиж
- б) Компьютерт шивж
- в) Аудио/ видео бичлэгээр
- г) Бусад хэлбэрээр

2. Шүүх хуралдааны үеэр шүүх хуралдааны тэмдэглэлийг үнэн зөв бичиж буй эсэхийг хянах дэлгэц байсан уу?

Тийм Үгүй

3. Шүүхийн тогтоолын агуулга: (2 буюу түүнээс дээш шүүгдэгч оролцсон бол 1-ээс дээш хариултыг сонгож болно)

- а) Шүүгдэгчийг цагаатгасан
 - б) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон
 - в) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцсон боловч Өршөөл үзүүлэх тухай хуулийн дагуу ялыг өршөөн хэлтрүүлсэн
 - г) Хавтаст хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан
 - д) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч тэнссэн
 - е) Шүүгдэгчийг гэм буруутайд тооцож ял оноосон боловч ял эдлүүлэхийг хойшлуулсан
 - ё) Бусад _____
- _____

4. Шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон бол шүүхээс оногдуулсан ялын хэмжээ нь улсын яллагчийн яллах дүгнэлтэд зааснаас ялгаатай байсан уу?

- а) Ижил ял оноосон
- б) Илүү хөнгөн ял оноосон
- в) Мэдэхгүй

5. Шүүгч шүүхийн тогтоолд давж заалдах эрхийг сануулсан уу?

- Тийм Үгүй

6. Шүүгч шүүхийн тогтоолыг шүүгдэгчдэд тайлбарлан ойлгуулсан уу?

- Тийм Үгүй

7. Ажиглагчийн дүгнэж байгаагаар шүүхийн тогтоол нь:

а) Хангалттай нотлох баримтад тулгуурлаж гарсан

- Тийм Үгүй

б) Хагас дутуу байдлаар үнэлж шийдвэр гарсан

- Тийм Үгүй

8. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгч оролцсон уу?

- Тийм Үгүй

Оролцсон бол тэдний овог нэр:

1. _____

2. _____

3. _____

9. Иргэдийн төлөөлөгч дүгнэлтээ уншиж сонгосон уу?

- Тийм Үгүй

10. Иргэдийн төлөөлөгчийн дүгнэлтийн агуулга:

а) шүүгдэгч гэм буруутай

б) шүүгдэгч гэм буруугүй

в) шүүгдэгч гэм буруутай эсэх талаар тодорхой дүгнэлт гаргаагүй

3. Шүүхийн нөхцөл байдал болон шүүгч, шүүхийн ажилтнуудын харилцааны байдал

1. Шүүхийн байр нь цэвэр цэмцгэр, хүндэтгэл төрүүлэхүйц байсан уу?

Тийм Үгүй

2. Шүүх хуралдааны танхим цэвэр, тохилог, хүндэтгэл төрүүлэхүйц байсан уу?

Тийм Үгүй

3. Шүүх хуралдаанд оролцогчдын яриа тод сонсогдож байсан уу?

Тийм Үгүй

4. Шүүх хуралдааны танхимын микрофон, чанга яригч хэвийн ажиллагаатай байсан уу?

Тийм Үгүй

5. Шүүгч өмсгөлөө өмссөн байсан уу?

Тийм Үгүй

6. Шүүх бүрэлдэхүүн орж ирэхэд шүүхийн танхимд байсан хүмүүс босож хүндэтгэл үзүүлсэн үү?

Тийм Үгүй

7. Шүүх хуралдааны дэгийг оролцогчдод тайлбарлаж таниулсан уу?

Тийм Үгүй

8. Шүүхийн танхимд журам сахиулах хуяг байсан уу?

Тийм Үгүй

9. Шүүхийн журам сахиулах хуяг хуралдааныг дуустал танхимыг орхилгүй байсан уу?

Тийм Үгүй

10. Шүүх хуралдааны дэг зөрчигдөж байсан уу?

Тийм Үгүй

11. Тийм бол шүүгч ямар арга хэмжээ авсан бэ? (10-р асуултад Тийм гэж хариулсан бол энэ асуултыг бөглөнө)

12. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааны бэлтгэлийг бүрэн хангасан байсан уу?

Тийм Үгүй

13. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шаардлагатай техник хэрэгслийг шүүх хуралдаан эхлэхээс өмнө бэлэн болгосон байсан уу?

Тийм Үгүй

14. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга албаны байдлаар хувцасласан байсан уу?

Тийм Үгүй

15. Шүүх хуралдаан эхлэхэд бүх оролцогчид зохих байраа эзэлсэн байсан уу?

Тийм Үгүй

16. Шүүх хуралдааны үеэр аудио видео бичлэг хийгдэж байсан уу?

Тийм Үгүй

17. Шүүхийн харуул хуягийн иргэдтэй харилцах байдал таны ажигласнаар:

- а) Эелдэг, уриалагхан
- б) Энгийн
- в) Хөндий хүйтэн

- г) Бүдүүлэг, дээрэнгүй
- д) Ялгамжтай
- е) Мэдэхгүй

18. Шүүхийн нарийн бичгийн даргын харилцаа таны ажигласнаар:

- а) Эелдэг, уриалагхан
- б) Энгийн
- в) Хөндий хүйтэн
- г) Бүдүүлэг, дээрэнгүй
- д) Ялгамжтай
- е) Мэдэхгүй

19. Шүүхийн дэг сахиулах хуягийн харилцаа таны ажигласнаар:

- а) Эелдэг, уриалагхан
- б) Энгийн
- в) Хөндий хүйтэн
- г) Бүдүүлэг, дээрэнгүй
- д) Ялгамжтай
- е) Мэдэхгүй

20. Шүүгч шүүх хуралдааны оролцогч нартай харилцах байдал таны ажигласнаар:

- а) Эелдэг, уриалагхан
- б) Энгийн
- в) Хөндий хүйтэн
- г) Бүдүүлэг, дээрэнгүй
- д) Ялгамжтай
- е) Мэдэхгүй

Огноо:

Хурал болсон газар:

Ажиглагчдын гарын үсэг:

(Бусад анхаарал татсан, мэдээлбэл зохих асуудлыг үлдсэн зайнд бичиж хуудас тус бүрд асуулгын хуудасны кодыг тавьж гарын үсэг зурж баталгаажуулна.)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2002 он.
3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. 2016 он.
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017 он.
5. Б.Бат-Эрдэнэ. Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. Ерөнхий анги. УБ., 2000 он.
6. Н.Лүндэндорж. Төрийн онол. УБ., 2008 он.
7. Н.Туяа, М.Ариунаа, Р.Оюунбадам, С.Мойлтмаа. хамтын бүтээл. Шүүх хуралдааны ажиглалтын тайлан. УБ., 2011 он.
8. Н.Туяа, П.Бадамрагчаа. Шүүх хуралдааны ажиглалт. Судалгааны нэгдсэн тайлан. УБ., 2015 он.
9. Нээлттэй Нийгэм Форум. Шүүх хуралдааны ажиглалт судалгааны тайлан. УБ., 2017 он.
10. OSCE. Handbook for Monitoring administrative justice. (2013), Printed by Centrum Poligrafii.
11. Norwegian institute of human rights. By Tor Böhler, Trond Dolva, Donna Gomien and Marit Mjhlum. Manual on Human Rights Monitoring An Introduction for Human Rights Field Officers. Chapter 8., (2011)